



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 05

№ 01/07 ДУА-2018/120/СТА-ТЦГЗ

Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар **825,636.00** /найман зуун хорин таван мянга зургаан зуун гучин зургаан/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Цалингийн сангаас “Бага олимп болон гамшгаас хамгаалах сургуулилт”-д оролцсон албан хаагчдад **665,436.00** /Зургаан зуун жаран таван мянган дөрвөн зуун гучин зургаа/ төгрөгийн урамшуулалт олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолын 2.а-д /Бүх шатны төсөв захиргач нарын салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтралах зэрэгээр орон тоо, цагин холс, урсгал зардлыг бууруулах, батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх эрхийг олгох/ заасныг тус зөрчсөн байна.

- Батлагдсан жишиг хэмжээг мөрдөлгүй нийт 160,200.00 /нэг зуун жаран мянга хоёр зуун/ төгрөгийн хүнсний материалыг дутуу олгосон.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 04 сарын 08-ны өдрийн 113 тоот тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэм хэмжээ, дэглэм”-ийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага огх, хууль тогтоомжс, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага огх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/, 4.1.6 дахь /Аудитаар илэрсэн зорчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлэсгүй/, 4.1.7-т /Хууль тогтоомжс зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож,

дэвтэн гаргуулахгүй байх үр нолоотэй гэж үзсэн бусад нохцол байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллах;
2. Батлагдсан жишиг хэмжээг баримтлан зарцуулалтыг хийх;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Цэцэрлэгийн төсвийн шууд захирагч Х.Цэрэн, нягтлан бодогч А.Отгонмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:



ЗӨВШӨӨРСӨН:



АУДИТОР Д.ОЮУН-ЭРДЭНЭ

НЯГТЛАН БОДОГЧ

Х.ЦЭРЭН

3Г40001

4817144213
ЗЮА0039 9033475

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллагаа эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.